

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/125/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 220

танай _____ -ны № _____ -т

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа

011020208

тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд, холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	233,918,396.30	361,099,084.69
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	147,962,384.09
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	147,962,384.09
3121	Төгрөг	0.00	147,962,384.09
31211	Төрийн сангийн харилцах	0.00	147,962,384.09
35	БАРАА МАТЕРИАЛ	233,918,396.30	213,136,700.60
351	Түүхий эд материал	199,000.00	-
35130	Эм боох материал	199,000.00	-
354	Хангамжийн материал	233,719,396.30	213,136,700.60
35410	Бичиг хэргийн материал	3,193,668.00	2,031,465.00
35420	Аж ахуйн материал	22,421,511.00	18,486,589.00
35450	Барилгын засварын материал	1,288,760.00	-
35470	Бусад хангамжийн материал	206,815,457.30	192,618,646.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,665,885,352.94	2,021,655,037.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,665,885,352.94	2,021,655,037.30
392	Биет хөрөнгө	1,460,224,352.94	1,816,435,037.30
39201	Барилга, байгууламж	1,470,166,540.10	1,758,067,370.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,738,922.96)	(97,315,201.50)
39205	Машин, тоног төхөөрөмж	151,099,683.30	244,541,119.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(121,027,432.26)	(120,643,654.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,617,624.00	81,217,624.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,643,139.24)	(56,387,675.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,250,000.00)	(15,000,000.00)
39217	Номын фонд	-	6,955,455.00
393	Биет бус хөрөнгө	205,661,000.00	205,220,000.00
39301	Програм хангамж	2,072,500.00	2,292,500.00
39302	Хасагдуулга	(1,411,500.00)	(2,072,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	205,000,000.00	205,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,899,803,749.24	2,382,754,121.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,899,803,749.24	2,382,754,121.99
51	Засгийн газрын хувь оролцоо	1,899,803,749.24	2,382,754,121.99
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	442,534,825.40	442,534,825.40
51101	Өмч: -Төрийн өмч	442,534,825.40	442,534,825.40
512	Хуримтлагдсан үр дүн	1,390,185,693.45	1,873,136,066.20
51210	Өмнөх үеийн үр дүн	1,390,185,693.45	(509,618,055.79)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,382,754,121.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,083,230.39	67,083,230.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,899,803,749.24	2,382,754,121.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,385,918,163.25	4,363,111,649.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,190,170.25	2,245,479,543.64
120	Нийтлэг татварын бус орлого	54,190,170.25	2,245,479,543.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,190,170.25	2,245,479,543.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,909,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		1,992,763,274.34
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		246,807,269.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,442,793.00	2,117,632,106.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,945,285,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,945,285,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,248,293.00	94,233,306.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,248,293.00	94,233,306.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,194,500.00	78,112,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,194,500.00	78,112,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,370,987,974.25	1,980,357,527.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,370,987,974.25	1,980,357,527.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,297,668,572.31	1,703,103,061.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,047,715,597.00	1,329,053,156.21
210101	Үндсэн цалин	763,243,700.00	947,612,220.79
210102	Нэмэгдэл	209,593,380.00	323,187,657.87
210104	Урамшуулал	74,878,517.00	58,253,277.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,253,117.02	165,721,398.70
210201	Тэтгэврийн даатгал	97,343,849.73	113,459,589.09
210202	Тэтгэмжийн даатгал	10,477,441.82	13,355,345.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,381,873.46	10,630,496.39
210204	Ажилгүйдлийн даатгал	2,095,268.36	2,569,120.39
210205	Эрүүл мэндийн даатгал	20,954,683.65	25,706,847.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,208,500.00	33,080,861.84
210301	Гэрэл, цахилгаан	2,646,791.17	5,498,602.63
210302	Түлш, халаалт	15,830,488.83	15,405,469.21
210303	Цэвэр, бохир ус	4,731,220.00	12,176,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,479,841.04	75,906,547.70
210408	Бараа материал акталсны зардал	17,355,840.00	75,906,547.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,615,130.00	24,229,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,615,130.00	5,909,000.00

**Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	17,960,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,865,147.25	75,112,097.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,115,000.00	27,321,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,020,752.00	250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,729,395.25	47,540,597.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,319,401.94	277,254,466.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,535,146.00	268,359,306.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,520,200.00	174,126,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,866,546.00	94,233,306.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,784,255.94	8,895,160.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,784,255.94	8,895,160.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>14,930,189.00</u>	<u>2,382,754,121.99</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>14,930,189.00</u>	<u>2,382,754,121.99</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,331,727,993.00</u>	<u>2,123,541,106.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,909,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,909,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,909,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,909,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,331,727,993.00	2,117,632,106.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,945,285,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,945,285,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,248,293.00	94,233,306.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,248,293.00	94,233,306.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,194,500.00	78,112,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,194,500.00	78,112,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,331,727,993.00</u>	<u>1,899,146,361.91</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,331,727,993.00	1,899,146,361.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,258,408,591.06	1,621,891,895.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,047,715,597.00	1,329,053,156.21
210101	Үндсэн цалин	763,243,700.00	947,612,220.79
210102	Нэмэгдэл	209,593,380.00	323,187,657.87
210104	Урамшуулал	74,878,517.00	58,253,277.55

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,253,117.02	165,721,398.70
210201	Тэтгэврийн даатгал	97,343,849.73	113,459,589.09
210202	Тэтгэмжийн даатгал	10,477,441.82	13,355,345.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,381,873.46	10,630,496.39
210204	Ажилгүйдлийн даатгал	2,095,268.36	2,569,120.39
210205	Эрүүл мэндийн даатгал	20,954,683.65	25,706,847.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,208,500.00	33,080,861.84
210301	Гэрэл, цахилгаан	2,646,791.17	5,498,602.63
210302	Түлш, халаалт	15,830,488.83	15,405,469.21
210303	Цэвэр, бохир ус	4,731,220.00	12,176,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,116,000.00	1,194,600.00
210604	Урсгал засвар	1,986,000.00	1,194,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,154,130.00	23,942,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,154,130.00	5,909,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	18,033,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,067,041.00	68,899,679.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,309,400.00	41,850,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,757,641.00	27,049,599.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,319,401.94	277,254,466.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,535,146.00	268,359,306.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,520,200.00	174,126,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,866,546.00	94,233,306.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,784,255.94	8,895,160.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,784,255.94	8,895,160.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>224,394,744.09</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	76,432,360.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	76,432,360.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	76,432,360.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	76,432,360.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(76,432,360.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	147,962,384.09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	147,962,384.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	442,534,825.40	67,083,230.39	-509,618,055.79	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			2,382,754,121.99	2,382,754,121.99
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	442,534,825.40	67,083,230.39	1,873,136,066.20	2,382,754,121.99

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,029,307,800.00	1,872,450,255.75
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,029,307,800.00	1,872,450,255.75
210	Бараа, үйлчилгээний зардал	1,849,097,400.00	1,698,324,255.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,452,469,500.00	1,329,053,156.21
210101	Үндсэн цалин	1,080,022,400.00	947,612,220.79
210102	Нэмэгдэл	346,765,500.00	323,187,657.87
210104	Урамшуулал	25,681,600.00	58,253,277.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,678,700.00	165,721,398.70
210201	Тэтгэврийн даатгал	123,566,700.00	113,459,589.09
210202	Тэтгэмжийн даатгал	14,537,400.00	13,355,345.66
210203	ҮОМШӨ ний даатгал	11,619,900.00	10,630,496.39
210204	Ажилгүйдлийн даатгал	2,905,000.00	2,569,120.39
210205	Эрүүл мэндийн даатгал	29,049,700.00	25,706,847.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,975,600.00	33,080,861.84
210301	Гэрэл цахилгаан	5,916,800.00	5,498,602.63
210302	Түлш, халаалт	20,296,800.00	15,405,469.21
210303	Цэвэр, бохир ус	15,762,000.00	12,176,790.00
2106	Эд хогшил худалдан авах	1,194,600.00	1,194,600.00
210604	Урсгал засвар	1,194,600.00	1,194,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	23,942,300.00	23,942,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,909,000.00	5,909,000.00
210806	Мэдээллийн технологийн зардал	18,033,300.00	18,033,200.00

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	147,836,700.00	145,332,039.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,786,800.00	118,282,440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,049,900.00	27,049,599.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,210,400.00	268,359,306.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	180,210,400.00	268,359,306.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	180,210,400.00	174,126,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,029,307,800.00	2,020,412,639.84
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,945,285,900.00	1,945,285,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,945,285,900.00	1,945,285,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	78,112,900.00	69,217,739.84
132001	Орон нутгийн төсвөөс	78,112,900.00	69,217,739.84
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,909,000.00	5,909,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,909,000.00	5,909,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	147,962,384.09

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	94,233,306.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	94,233,306.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,233,306.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,233,306.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	94,233,306.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	94,233,306.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,233,306.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,233,306.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3 зөрчил¹ илэрснээс, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагад мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль тогтоол, тушаал зааврыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлагаажаагүй байна. Энэ нь УСНББОУСЗ.7-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтмол практик юм" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 удгаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт дүрэм журамтай уялдуулан өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулах

2. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль тогтоол, тушаал зааврыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.	1	-			1	-		
Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.	1	-			1	-		
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	1	-			1	-		
Дүн		3	-	-	-	3	-	